



## ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТРЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2018 он 05 сар 09 өдөр

№ 14

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын дүрмийн 2.4.2 дахь заалтыг үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын арбитрчид, эвлэрүүлэн зуучлагч нарт онолын мэдлэг, практик ур чадварыг хөгжүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх зорилгоор “Арбитрч, эвлэрүүлэн зуучлагчдын сургалтын журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Журмыг 2018 оны 6 дугаар сарын 1-ны өдрөөс мөрдөж эхэлсүгэй.
3. Журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны дарга Ч.Дарьсүрэнд даалгасугай.
4. Журмын дагуу бүртгэл, хөтлөлт, үр дүнгийн талаарх тайланг улирал тавьж гаргаж ажиллахыг Ажлын албаны нарийн бичгийн дарга Г.Анужинд даалгасугай.

  
 Ганбатын БАТЗАЯА



## **АРБИТРЧ, ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАГЧДЫН СУРГАЛТЫН ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Монголын олон улсын ба үндэсний Спортын арбитр /цаашид “Спортын арбитр” гэх/-аас арбитрчид болон эвлэрүүлэн зуучлагч нарт сургалт зохион байгуулах, сургалтад нийт арбитрчид, эвлэрүүлэн зуучлагч нарыг хамруулж онолын мэдлэг, практик ур чадварыг хөгжүүлэх, давтан сургах, мэргэшүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Энэ журмаар Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын арбитрч, эвлэрүүлэн зуучлагчид чиглэсэн сургалтын үйл ажиллагаа, түүнтэй холбогдон гарах харилцааг зохицуулна.

### **ХОЁР. СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ**

- 2.1. Арбитрч, эвлэрүүлэн зуучлагчдын сургалтыг улирал тутамд нэг удаа зохион байгуулна.
- 2.2. Сургалтыг мэргэжлийн багшаар удирдуулан орчин үеийн шаардлага хангасан нөхцөлд зохион байгуулна.
- 2.3. Арбитрч, эвлэрүүлэн зуучлагчдын сургалт явуулах байр танхим, багш нарын сургалтын хөлс болон холбогдон гарах зардлыг Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитр хариуцна.
- 2.4. Арбитрч, эвлэрүүлэн зуучлагчдын сургалт хийх хугацааг урьдчилан /нэг сарын өмнө/ санал авч, тэдний гаргасан санал дээр үндэслэн сургалтын хугацааг товлон.
- 2.5. Сургалтыг Эвлэрүүлэн зуучлах дүрэм, Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмээр онол, практикийн хичээл болон бусад хууль, журам, арбитрчдын санал болгосон хичээлийн сэдвээр сургалт явуулж сургалтын төгсгөлд чөлөөт ярилцлага явуулна.

### **ГУРАВ. СУРГАЛТЫН ЦАГИЙН КРЕДИТ ТООЦОХ**

- 3.1. Сургалт зохион байгуулах хугацааг бүх арбитрч, эвлэрүүлэн зуучлагчдаас санал авч товлосон учраас сургалтад Спортын арбитрч, эвлэрүүлэн зуучлагчид хамрагдан оролцох боломжоор хангагдана.
- 3.2. Сургалтын хуваарийн дагуу зохион байгуулагдсан сургалтын цагийг 100% гэж үзээд түүнээс хувилж кредит цагийг тооцно.
- 3.3. Зохион байгуулан явуулсан нэг удаагийн сургалтын цагийг 2 кредитээр тооцох бөгөөд сургалтад бүрэн суусан тохиолдолд кредит цагийг тооцох болно.

- 3.4. Арбитрч, эвлэрүүлэн зуучлагч нь зохион байгуулсан нэг удаагийн сургалтын цагийг 2 кредитээр тооцох бөгөөд жилд нийт 8 кредит цагийн үнэлгээг авсан байна.
- 3.5. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийт сургалтын 6 кредит цагийн үнэлгээ аваагүй тохиолдолд Арбитрчаас түдгэлзүүлэх, чөлөөлөх асуудлыг Ерөнхийлөгчийн саналыг харгалзан Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитрын холбооны Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.
- 3.6. Арбитрч, эвлэрүүлэн зуучлагчдын жилийн ажлыг дүгнэхэд сургалтад хамрагдсан байдлыг нэг үзүүлэлт болгон тооцно.

Жич: Тухайн сургалтад бүрэн суугаагүй тохиолдолд суусан цагийг дүйцүүлэн тооцно.